



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 410

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалт, Дорноговь аймгийн Засаг даргын 2023 оны А/69 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон, 40,000,000.00 (дөчин сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ж.Мөнх-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэлд бүртгүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005866
22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн
410 дугаар тогтоолын хавсралт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ
ТӨРИЙН ӨМЧИТ ХҮЛЭЭН АВЧ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ХАРЬЯА ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХЭЛТЭСТ ЭЗЭМШҮҮЛЖ, БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Хьюндай старекс (дугааргүй)	ш	1	40,000,000	40,000,000.00
	Дүн				40,000,000.00